

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨМЖ**

Улаанбаатар хот, 2012 он

Гарчиг

Нэг. Менежментийн төлөвлөгөөний тухай нийтлэг ойлголт.....	3
1.1. Менежментийн төлөвлөгөө, түүний ач холбогдол	3
1.2. Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад тавигдах шаардлагууд	4
1.3. Менежментийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд	5
1.4. Менежментийн төлөвлөгөөний нэр томъёо	6
Хоёр. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл үе шатууд.....	8
2.1. Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, оролцогч талууд, тэдгээрийн оролцоог хангах	8
2.2. Төлөвлөгөө боловсруулах баг бүрдүүлэх, багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь	10
Гурав. Менежментийн төлөвлөгөө боловсруулах үе шат.....	12
3.1. Анхдагч мэдээлэл цуглуулах.....	12
3.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөг боловсруулах.....	13
3.3. Менежментийн төлөвлөгөөний эхний хувилбарыг боловсруулж олон нийтээр хэлэлцүүлэн санал авах	19
3.4. Менежментийн төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж батлуулах.....	20
Дөрөв. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх механизм.....	20
Тав. Менежментийн төлөвлөгөөний үнэлгээ ба мониторинг	22
Зургаа. Бусад хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулах нь.....	23
Долоо. Хавсралтууд.....	26

Нэг. Менежментийн төлөвлөгөөний тухай нийтлэг ойлголт

1.1. Менежментийн төлөвлөгөө, түүний ач холбогдол

Байгаль орчныг хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн комиссоос (WCPA) тусгай хамгаалалттай газар нутгийг (ТХГН) стратегийн зорилт болон үйл ажиллагааны зохистой тэнцлийг хангасан, улс төрийн нөлөөллөөс ангид, оролцогч талуудын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, бие даасан байх ёстой гэж үздэг. Ялангуяа Дэлхийн өвд багтсан ТХГН-ийн хувьд менежментийн төлөвлөгөөг зайлшгүй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатайг ЮНЕСКО-ийн үйл ажиллагааны удирдамжинд зааснаас гадна олон улсын хандивлагч нарын зүгээс менежментийн төлөвлөгөөтэй тусгай хамгаалалттай газруудад санхүүгийн дэмжлэг үзүүлж тодорхой төсөл хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлэх сонирхол ч байдаг. Өнөө үед менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах талаар баримтлах улсын бодлого, хууль, дүрэм, журмын дагуу боловсруулан баталгаажуулж, хуульчлах асуудал нийтлэг жишиг болжээ.

Манай улсын хувьд 1998 онд УИХ-аар батлагдсан “ТХГН-ийн Үндэсний хөтөлбөр”-т ТХГН бүр өөрийн үйл ажиллагааны урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ... гэж заасан нь ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх талаар гарсан анхны стратегийн баримт бичиг юм.

ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө нь тухайн ТХГ дахь хамгаалах үнэт зүйлсийг тодорхойлон, өнөөгийн төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тэдгээрт учирч буй болон ирээдүйд учирч болох аюул, дарамтад дүн шинжилгээ хийсний үндсэнд алсын хараа, эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон, дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тодорхой хугацааг хамарсан, оролцогч талуудаар хүлээн зөвшөөрөгдсөн, эрх бүхий байгууллагаар баталгаажсан, өөрөөр хэлбэл тусгай хамгаалалтанд авсан газрыг өнөө болон ирээдүйд хэрхэн яаж удирдан зохион байгуулах чиг зүгийг заасан “Луужин” гэж ойлгож болно.

Нөгөө талаар ТХГН-ийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглахад шаардлагатай хүний болон санхүүгийн нөөц, техник тоног төхөөрөмж зэрэг нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны удирдамж юм. Төлөвлөгөө нь олон улсын хэмжээнд нэгдэн орсон конвенци, бусад эрх зүйн актууд, үндэсний бодлого, байгаль орчны болон ТХГН-ийн талаарх дүрэм журмууд, бүс нутаг ба орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэгт нийцсэн байна. Менежментийн төлөвлөгөө нь нэг загварын, хэвшмэл, зогсонги үйл явц биш, өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болж байх үүднээс уян хатан шинж чанарыг агуулсан байнгын үйл явц байна. Ийм учраас ТХГН тус бүр өөрийн онцлог байдлаас шалтгаалан харилцан адилгүй зорилт дэвшүүлж, шийдвэрлэх арга замаа тодорхойлсон төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

Менежментийн төлөвлөгөөний ач холбогдол.

- Менежментийн төлөвлөгөөг ТХГН-ийн талаарх бүрэн мэдээлэлд суурилан

- боловсруулсан тул түүний зорилго, үнэ цэнэ, нөөцийг бүрэн тооцож, менежментийн оновчтой шийдэл олох боломж олгодог;
- Хамгаалалтын захиргааны өдөр тутмын болон дунд,урт хугацааны үйл ажиллагааны удирдамж болохын хувьд эрхэм зорилго, зорилт, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд тусалдаг;
 - ТХГН-ийн менежментийн залгамж чанар, тасралтгүй байдлыг хангаж өгдөг;
 - Байгууллагын менежментийн үр ашиг, бүтээмжийг тодорхойлж дэвшүүлсэн зорилтоо хэрхэн хэрэгжүүлсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, өөрчлөх шаардлагатай эсэхийг тооцдог;
 - Санхүү, материаллаг бааз болон хүний нөөцийн зохистой төлөвлөлт хийх, хөрөнгийг зөв төсөвлөж зарцуулах, хяналт тавих боломж олгодог;
 - ТХГН-ийн удирдлага, мэргэжилтнүүдтэй хариуцлага тооцох, гүйцэтгэлийн сахилга батыг сахиулах хэрэгсэл болдог. Менежментийн төлөвлөгөөн дээр түшиглэн хувь хүмүүсийн ажил үүргийн хуваарийг тогтоодог;
 - ТХГН-ийн менежментэд оролцогч талууд буюу хамгаалалтын захиргаа, нутгийн иргэд, шийдвэр гаргагчдын хамтын ажиллагаанд холбогч гүүр нь болдог;
 - ТХГН-ийн талаархи олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтэнд олон нийтийн хяналтыг бий болгох нөхцлийг бүрдүүлдэг;
 - ТХГН-ийн менежментэд олон улсын байгууллага, хандивлагчдыг татан оролцуулах, санхүүгийн эх үүсвэрийг олоход тусалдаг.

1.2. Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад тавигдах шаардлагууд

Менежментийн төлөвлөгөө боловсруулахад дараах шаардлагууд тавигдана Үүнд:

- Менежментийн төлөвлөгөө нь ТХГН-ийн талаар олон улсын байгууллагуудын тавьдаг нийтлэг зарчим, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенцуудын үзэл санаатай нийцсэн,
- Үндэсний болон бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан,
- Байгаль орчны багц хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн,
- Менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, байгаль хамгаалах бүлэг, нөхөрлөлүүдийн оролцоог хангахуйц бүтэц, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг хангасан,
- ТХГН-ийн экосистем, биологийн төрөл зүйл, байгалийн нөөц баялгийг ашиглах, хамгаалах талаар урьд нь хэрэгжиж ирсэн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх замаар цаашид хийгдэх үйл ажиллагааны оновчтой хувилбарыг сонгон авсан,
- ТХГН-ын хил залгаа болон хилийн дотор байрладаг нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагуудтай ТХГН-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдмэл чанарыг хангасан,
- Менежментийн төлөвлөгөө нь нутгийн уугуул иргэдийн соёл, уламжлал, ёс заншилыг хадгалан үлдэх, хөгжүүлэхийг дэмжсэн,

- ТХГН-ийн хамгаалалтын менежментэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж идэвхижүүлэхийн тулд тэдний нийгэм эдийн засгийн байдлыг өөрчлөн сайжруулахад чиглэгдсэн,
- Менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөцийг харгалзсан,
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд уг төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад хангалттай чадавхижсан, хамтын ажиллагаа нь итгэлцэлд тулгуурласан,
- Менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналтад оролцооны аргыг гол зарчимаа болгосон,
- Менежментийн төлөвлөгөө боловсруулахад тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аль болох орчин үеийн шинэлэг арга зүй, компьютерийн программ ашигласан,
- БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулан гаргасан “Төлөвлөлт хийхэд зориулсан гарын авлага” болон “Баримт бичиг боловсруулах тогтсон стандарт зэргийг баримталсан,
- Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт нь хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр хангагдсан,
- Хил дамнасан ТХГН-ийн тухайд менежментийн төлөвлөгөө нь хилийн дагуух Улсуудтай хийсэн хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

1.3. Менежментийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд

Менежментийн төлөвлөгөө нь дараах ерөнхий агуулга, бүтэцийн хүрээнд бичигдэнэ.

Хураангуй дүгнэлт:

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан гол асуудлууд, тэдгээрийн шийдлийг нэгтгэсэн дүгнэлтийг энэ хэсэгт бичнэ. Сонирхогч талууд төлөвлөгөөг бүхэлд нь унших шаардлагагүй, эсвэл боломжгүй тохиолдолд энэ хэсэгт гол анхаарлаа хандуулдаг. Иймд тухайн менежментийн төлөвлөгөөний гол асуудлыг хураангуйлан тусгасан товч мэдээллийг өгнө.

Удиртгал:

Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, менежментийн гол зорилго, төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл, баримталсан зарчмууд, хэрэглэсэн арга зүй болон төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн талаарх товч мэдээлэл, төлөвлөлтийн үйл явц /эхэлсэн дууссан хугацаа, менежментийн төлөвлөгөө боловсруулах явцад гарсан онцлог үйл явдал, бэрхшээл г.м./ оролцсон байгууллага, хүмүүсийн талаарх мэдээллийг товчлон оруулна.

ТХГН-талаарх ерөнхий мэдээлэл:

ТХГН-ийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй оруулна (тухайн газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авсан зорилго, түүх, байгаль газар зүй, экосистемийн онцлог, биологийн олон янз байдал, түүх соёлын дурсгал, хил хязгаар, дотоод бүсчлэл, дэд бүтэц, газар ашиглалт,

нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хүн ардын амьжиргаа, ажил эрхлэлт, хамгаалалтын захиргааны материаллаг бааз, хүний нөөц г.м.)

ТХГН дахь хамгаалах гол үнэт зүйлс, тулгамдсан асуудлуудад хийх дүн шинжилгээ:

ТХГН-ийн хамгаалах гол үнэт зүйлсүүдийг тодорхойлон, тэдгээрээс нэн тэргүүнд хамгаалах зүйлсийг сонгож, тэдгээрт нөлөөлж буй өнөөгийн болон болзошгүй дарамт, аюул заналд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүнг энэ хэсэгт бичнэ.

Зорилго ба зорилтууд:

Энэ хэсэгт тухайн газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авсан урт удаан хугацааны эрхэм зорилго, түүнд хүрэх менежментийн тусгайлсан зорилгууд буюу ирээдүйд хүлээж байгаа үр дүнгүүд буюу зорилтуудыг товч томъёолон оруулна.

Менежментийн арга хэмжээ:

Зорилго, зорилтуудаа биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээг хүснэгт хэлбэрээр төлөвлөж оруулна. Тухайлбал: хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах эзэн, хамтран гүйцэтгэх талууд, шаардагдах төсөв зэргийг тусгасан байна. Менежментийн нэг зорилтод хүргэх хэд хэдэн арга хэмжээнд нэгдсэн шалгуур үзүүлэлт тавьж болно.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааг үнэлэх мониторинг:

Менежментийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад хяналт үнэлгээ - мониторинг хийх үйл явцыг тусгана.

1.4. Менежментийн төлөвлөгөөний нэр томъёо

Алсын хараа: Тухайн ТХГ ирээдүйд ямар байдалтай болох талаарх төсөөллийн товч тодорхойлолт.

Амьдрах чадварын үнэлгээ: Экосистем, бүлгэмдэл, зүйлийн одоогийн байдал, цаашид оршин тогтноход нөлөөлөх хүчин зүйлийн үнэлгээ.

Арга зам: Зорилтуудад хүрэх стратеги.

Аюул занал: хамгаалах үнэт зүйлд учирч байгаа болон болзошгүй дарамтын шууд болон шууд бус шалтгаан буюу дарамтыг үүсгэж буй хүчин зүйлүүд.

Байгалийн жам ёсны өөрчлөлт: Байгаль дээрх үзэгдлүүд, популяци зэрэг нь өөрийн жамаар тодорхой хэлбэлзэлд орж байдаг динамик шинж чанартай. Харин хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас энэ хэлбэлзэл нь хэт ихэсч улмаар хүлцэх төвшнөөс хэтрэх үед тухайн зүйлд устах зэрэг аюул нүүрлэнэ.

Биологийн олон янз байдал: Ургамал, амьтан, бичил биетэн, тэдгээрийг агуулж байгаа амьдрах орчин, экосистемийн олон янз байдал, тэнд явагдаж буй үйл явцын нэгдэл. Биологийн олон янз байдлыг зүйлийн, генетикийн, амьдрах орчны олон янз байдал гэж ангилдаг.

Дарамт: Биологийн олон янз байдлын хэмжээ, нөхцөл, ландшафтын хүчин зүйл гэсэн экологийн чухал хүчин зүйлүүдийн аль нэгийг доройтуулж буй үйл явц. Тухайлбал аргаль хонины тоо толгой буурч байгаа нь хэмжээг, амьдрах орчин нь доройтож байна гэдэг нь нөхцөлийг, харин тархац багассан гэвэл ландшафтын хүчин зүйлийг тус тус илэрхийлж байна.

Ландшафтын хүчин зүйл: Хамгаалах олон янз байдлын оршин тогтноход чухал хүрээлэн буй орчны экологийн горим, үйл явц ба холбогдох байдал.

Менежментийн төлөвлөгөө: ТХГ-ын хэтийн зорилго, биологийн болон соёлын нөөцийг хамгаалах тодорхой зорилтууд, тэдгээрт хүрэх арга зам, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичиг.

Менежментийн төлөвлөгөөний зорилго: ТХГ-ын хамгаалах үнэт зүйлийг хэвээр хадгалан үлдээх, төлөв байдлыг тодорхой цаг хугацаанд сайжруулахад чиглэсэн, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг тусгасан үр дүн.

Менежментийн зорилт: ТХГ-ын менежментийн ойрын ирээдүйд хүрэх зорилт ба төлөвлөж буй үр дүн. Зорилт нь тухай ТХГ-ын зайлшгүй хамгаалах үнэт зүйлсэд учирч буй дарамтыг бууруулахад чиглэсэн, хэмжиж болохуйц, тодорхой цаг хугацаатай, хэрэгжихүйц байна.

Менежментийн арга хэмжээ: Зорилтод хүрэх тодорхой арга хэмжээ бөгөөд хэд хэдэн үйл ажиллагааг багцалсан байж болно. Менежментийн арга хэмжээ нь зорилтод уялдсан, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоон, жилийн төлөвлөгөөнд тусгаж өгсөн байна.

Мониторингийн төлөвлөгөө: Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт, үр дүнд хүрч буй эсэхийг зохих шалгууруудыг ашиглан ажиглалт, тандалт хийх үйл явцын төлөвлөлт. Мониторинг хийхэд ашиглах шалгуур, мэдээлэл цуглуулах давтамж, хариуцах эзэн, хугацаа, төсөв зэргийг тусгана.

Менежментийн зөвлөл: Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцох талуудын хамтын ажиллагааг дэмжих зорилго бүхий зөвлөл.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ: Хамгаалах үнэт зүйлсэд учирч буй дарамт, тэдгээрийг үүсгэж буй аюул занал, түүний шалтгаануудыг задлан шинжлэх, улмаар тэдгээрийг шийдвэрлэхийн тулд тодорхойлсон үр дүнгүүдийг локиг дарааллаар тогтоох дүн шинжилгээ.

Хамгаалах үнэт зүйл: ТХГН дахь биологийн болон түүх соёлын ач холбогдол бүхий зүйлс. Тухайн ТХГ-ыг эдгээр үнэт зүйлсийг хамгаалах зорилгоор байгуулдаг.

Хэмжээ: Экосистемийн хамрах хэмжээ, эсвэл зүйлийн тоо, толгой гэх мэт хамгаалах биологийн олон янз байдлыг хэмжих ойлголт.

Хэтийн зорилго: Менежментийн төлөвлөлтийн тухайд хэтийн зорилго нь хамгаалах биологийн олон янз байдлын экологийн чухал хүчин зүйлийг хэвээр хадгалан үлдэх, сайжруулахад чиглэгдэнэ.

Үр дүнгийн хэлхээс: Нөхцөл байдлын дүн шинжилгээний явцад аюул заналыг үүсгэж буй шалтгаануудыг арилгах зорилгоор тогтоосон үр дүнгүүдийн локиг дараалал.

Логик дарааллыг тогтоосноор төлөвлөлтийн үйл явцын дараалал, хамгаалах үнэт зүйлийн зорилго, түүнд учруулж буй дарамтыг бууруулах, хамгаалалтын менежментийг сайжруулахад чиглэгдсэн эсэхийг шалгах боломжтой.

Шалгуур: *Аль нэгэн хүчин зүйлийн чиг хандлага болон тухайн үеийн байдлыг үнэлэх, хэмжиж болохуйц хувьсагдахуун.*

Шалтгаан, үр дагаврын шинжилгээ: *Аюул занал ямар шалтгаанаас үүдэлтэй болохыг дарааллаар тогтоох задлан шинжлэх үйл явц.*

Экологийн бүлгэмдэл: *Экологийн нэг нэгж болдоггүй ч, хамтдаа тохиолдох зүйлүүд. Жишээ нь: Үетэнт бүлгэмдэл: Хялгана, Саман ерхөг, Хиаг, Хазаар өвст бүлгэмдэл*

Экологийн чухал хүчин зүйл: *Биологийн олон янз байдлын оршин тогтноход зайлшгүй чухал болох зүйлийн урт хугацааны амьдралын мөчлөг, популяцийн бүтэц, зүйлийн бүрдэл, амьд болон амьгүй хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэл зэрэг нөхцлүүд. Тэдгээрийг хэмжээ, нөхцөл, ландшафтын хүчин зүйл гэсэн гурван бүлэгт хувааж үзнэ.*

Экосистем: *Амьтан ургамлын төрөл зүйлүүд нь хүрээлэн буй орчинтойгоо экологийн нэгэн нэгж болон оршиж буй бүлгэмдлүүдийн нэгдэл.*

Хоёр. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл үе шатууд

Хүрсэн байх үр дүн:

Менежментийн төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл үе шатанд дараах үр дүнд хүрсэн байна:

- Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, оролцогч талуудыг тогтоосон байна.
- Менежментийн төлөвлөгөө боловсруулах үе шат, хэрэглэх арга зүй тодорхой болсон байна.
- Төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, ажил үүргийн хуваарь, ажлын төлөвлөгөө гарсан байна.
- Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэр шийдэгдсэн байна.
- Хамгаалалтын захиргааны холбогдох мэргэжилтнүүд менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн байна.

2.1. Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, оролцогч талууд, тэдгээрийн оролцоог хангах

Менежментийн төлөвлөгөө нь тухайн газар нутаг дахь хамгаалалтын бодлого, байгалийн нөөц баялгийн хадгалалт, хамгаалалт, дагалт баялгийн зүй зохистой ашиглалт, байгалийн нөөцийн нөхөн сэргээлтийг сайжруулах, нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац, байршлыг тогтоох, нөхөн үржихүй, өсөлтийг хангах үүднээс ТХГ-ын дотоод бүсчлэл, тэдгээрийн хамгаалалтын дэглэмийг тогтоох, мөрдүүлэхэд, чиглэсэн байх ёстой.

Мөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хамгаалалтын захиргаа бүр бизнес төлөвлөгөөг боловсруулсан байна.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын ажилтнууд хариуцсан газар нутгийнхаа өнөөгийн байдал, цаашид хийх шаардлагатай ажлын талаар хамгийн сайн ойлголт, мэдээлэлтэй байхын зэрэгцээ тухайн газрын менежментийн үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэгчид учраас төлөвлөгөө боловсруулахад тэргүүлэх үүрэгтэйгээр оролцоно. БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь менежментийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжлийн удирдлагаар хангана.

Менежментийн төлөвлөгөө нь оролцооны арга дээр түшиглэсэн байх ба төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл үе шатнаас эхлэн оролцогчдын хүрээг тодорхойлно. Үүнд хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, орон нутгийн төр захиргаа, хууль хяналтын болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллагууд бүгд хамаарна.

Менежментийн төлөвлөгөө хэнд зориулагдсан гэдгийг тодорхойлно. Менежментийн төлөвлөгөө нь зөвхөн хамгаалалтын захиргааны ажлын хөтөлбөр биш, харин эрх баригчид, ард иргэд, бизнес эрхлэгч, ТХГН-ийн орчимд амьдардаг хүмүүст зориулагдсан байна.

Дээр дурьдсан үйл ажиллагаануудад орон нутгийн засаг захиргаа, байгаль орчны чиглэлийн мэргэжлийн нэгж, байгууллагууд, гадаад, дотоодын хандивлагчид, олон улсын болон төрийн бус байгууллагуудын мэргэжил, арга зүй, санхүүгийн дэмжлэг туслалцааг байнга авч ажиллахаар тооцож төлөвлөх нь чухал.

Оролцогч талуудыг хэрхэн сонгох вэ?

Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дээрх бүх талуудын төлөөллийг бүрэн хангасан байдлаар хамрагдах хүрээг оновчтой тодорхойлох нь төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх нэг болж өгнө. Оролцогч талуудыг сонгоход дараах нөхцлүүдийг харгалзана Үүнд:

- Газар зүйн байрлал: ТХГН, түүний орчны бүсэд амьдардаг нутгийн иргэд болон түр оршин суугчид,
- ТХГН-ийг ашиглах байдал: ТХГН-ийн байгаль, түүх соёлын нөөц баялгийг ашиглагчид /малчид, аялал жуулчлал эрхлэгчид/
- ТХГН хамгаалах үнэт зүйлсэд үзүүлэх нөлөөлөл: хамгаалах үнэт зүйлсэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж байгаа болон болзошгүй бүлгийн төлөөлөл
- Үндэстэн ястны ялгаа: Тухайн орон нутаг байдаг үндэсний цөөнх, шашин шүтлэгийн ялгаа, уугуул иргэдийн төлөөлөлийг харгалзан,
- Хүйсийн тэгш байдал: Эрэгтэй, эмэгтэй хүмүүс аливаа асуудлыг өөр өөр өнцгөөс хардаг тул нийгмийн зарим харилцаанд хүйсийн тэнцвэрт байдал чухал үүрэгтэй,
- Эрхэлж буй ажлын байдал: Төрийн албан хаагчид, менежер, газар ашиглагчид, уламжлалт аргаар гэрээгээр үйл ажиллагаа эрхлэгчид,

2.2. Төлөвлөгөө боловсруулах баг бүрдүүлэх, багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь

Менежментийн төлөвлөгөө боловсруулах үндсэн багийг тухайн хамгаалалтай газар нутгийн хэмжээ, онцлог, ач холбогдол, хамгаалалтын захиргааны болон орон нутаг дахь хүний нөөцийн боломж, чадавхи зэргийг харгалзан бүрдүүлэх бөгөөд багийн бүрэлдэхүүнд оролцох хүмүүст дараах шалгууруудыг тавина Үүнд:

- Ландшафт, байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежмент, экологийн эрх зүй, ТХГН-ийн менежмент талаар зохих мэдлэг, туршлагатай,
- Экологи, биологийн олон янз байдлын талаар судалдаг, энэ чиглэлээр мэргэшсэн
- Тухайн нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль, түүх, соёлын талын мэдлэгтэй,
- Оролцооны аргаар ажиллах чадвар, туршлагатай,
- Орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээний бодлого боловсруулах, удирдамж чиглэл өгөх чадвартай.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах багийг хамгаалалтын захиргааны дарга ахлана. Багийн ахлагч гишүүд дотроосоо нарийн бичгийн даргаа томилж ажиллуулна. ь

Багийн ахлагч дараах үүрэг хүлээнэ:

- Багийг чадварлаг, туршлагатай хүмүүсээр с бүрдүүлэхэд онцгой анхаарч, ярилцлага зохион байгуулсны үндсэн дээр гишүүдийн сонгоно.
- Төлөвлөгөө боловсруулах ажлын гол зохицуулагч байж, удирдан чиглүүлнэ.
- Төлөвлөгөөг боловсруулах бүхүе шатны төлөвлөлтийг хийж, зарцуулагдах төсөв хөрөнгийг тооцож гаргана.
- Төлөвлөгөөг боловсруулж дуусах хүртэл хугацааны ажлын хэсгийн гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг тогтооно.
- Багийн гишүүдтэй гэрээ байгуулж, хийх ажлыг хуваарьлан, ажлын төлөвлөгөөг гаргаж гүйцэтгэх цаг хугацааг товлон.
- Багийн гишүүдийн үйл ажиллагаанд хяналт, шаардага тавьж, үйл ажиллагааг нь зохицуулна. Төлөвлөлтийн үйл явцад зөвлөгөө өгнө.

Нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

- Төлөвлөлтийн явцад ажлын хэсгийн ахлагчийн удирдлага дор бүх үйл ажиллагааг зохицуулна,
- Менежментий төлөвлөгөөний агуулга, бүтцийн дагуу баримт материалуудыг цуглуулж нэгтгэнэ.
- Багийн гишүүдийн мэдээллийг нэгтгэж, материалуудыг эмхэтгэж хянан тохиолдуулна.
- Менежментийн төлөвлөгөөний төсөл, болон эцсийн хувилбарыг эмхэтгэж санал авах, батлуулахад бэлтгэнэ.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явцыг төлөвлөх, төсөө зохиох

Төлөвлөгөөг боловсруулж эхлэхээс өмнө багаараа хийх ажлын дарааллыг хэлэлцэнэ. Үүнд, н төлөвлөгөө боловсруулах ажил хэдэн үе шаттай байх, тухайн үе шат бүрт ямар

үйл ажиллагааг хэн, ямар хугацаанд гүйцэтгэх, хэдий хэмжээний төсөв хөрөнгө шаардлагатай гэдгийг нарийвчлан тогтооно.

Менежментийн төлөвлөгөө боловсруулалт дараах ерөнхий дараалалтай байна. Үүнд:

1. Анхдагч мэдээлэл цуглуулах
2. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хувилбарыг боловсруулж олон нийтэд хэлэлцүүлэн санал авах
4. Төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж батлуулах

Дээр дурьдсан үе шатны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эхлэх, дуусах хугацаа, хариуцах эзэн, шаардагдах төсвийг төлөвлөнө.

Жишээ нь:

МТ боловсруулах үе шатууд	Хэн хариуцах	Оролцогч талууд	Хугацаа	Төсөв
Анхдагч материал цуглуулах, сурталчилгаа хийх				
Цуглуулсан мэдээлэлүүдэд дүн шинжилгээ хийх				
МТ-ний анхны хувилбар боловсруулах, санал авах				
МТ-г эцсийн байдлаар боловсруулж дуусах, батлуулах				

Менежментийн төлөвлөгөө боловсруулах баг нь дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн ерөнхий төлөвлөгөө, үе шат бүрд задаргаа хийсэн нарийвчилсан төлөвлөгөөтэй байна.

Төлөвлөгөө боловсруулахад шаардагдах төсвийг хамгаалалтын захиргаанаас гаргах, шаардлагатай бол БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар шийдвэрлүүлэх, эсвэл олон улсын төсөл хөтөлбөрүүд болон бусад хандивлагч байгууллагуудад хандаж болно.

Гурав. Менежментийн төлөвлөгөө боловсруулах үе шат

3.1. Анхдагч мэдээлэл цуглуулах

Хүрсэн байх үр дүн:

- ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах талаар холбогдох талууд тодорхой мэдээлэл, төлөвлөлтийн хамрах хүрээ, оролцооны талаар ойлголттой болсон байна.
- ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй оруулах шаардлагатай үндсэн мэдээллүүдийг нэгтгэсэн байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Менежментийн төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан хялбаршуулсан сурталчилгааны материал, гарын авлага бэлтгэх /менежментийн төлөвлөгөөний ач холбогдол, мэдээлэл хэрхэн цуглуулах г.м./;
- Олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлахад тусгайлсан арга хэмжээ зохион байгуулах (уулзалт, ярилцлага, өдөрлөг), эсвэл багийн хурал, бүлэг нөхөрлөлийн уулзалт зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг ашиглах;
- Мэдээллийн бусад хэрэгслийг ашиглах (сонин сэтгүүл, ТВ, радио, мэдээллийн төвүүд, номын сан г.м.);
- ТХГН дахь айл өрх, бүлэг, нөхөрлөлүүд, аж ахуйн нэгж зэрэг оролцогч бусад талуудтай уулзалт зохион байгуулах (Оролцооны аргуудыг ашиглаж болно).
- Төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай анхдагч мэдээлэл цуглуулахын тулд хэрэгцээтэй мэдээллийн жагсаалт гаргах;
- Мэдээлэл авах тусгай маягтуудын бэлтгэн, олон нийтэд хүргүүлэх;
- Менежмент төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга цуглуулсан мэдээллүүдийг нэгтгэн, ажлын хэсгийн уулзалтанд танилцуулах,
- Урьд өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний материалыг авч нэгтгэх;
- Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад захиалга өгч, шинээр судалгаа хийлгэх.

Менежментийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай үндсэн мэдээллүүд:

- ТХГН-ийн газар зүйн байрлал, газар нутаг, талбайн хэмжээ

- ТХГН-ийн ангилал
- Хууль эрх зүйн статус, байгуулагдсан он
- ТХГН-тай холбогдсон хууль эрх зүйн актууд, дүрэм журам
- Газар зүйн мэдээлэл (цаг агаар, геологи, хотгор гүдгэр, ус, хөрсний тодорхойлолт)
- Түүх, соёлын ач холбогдлын талаарх мэдээ (экосистемийн онцлог, ард иргэд, байгаль орчны хоорондын шүтэлцээ, уламжлал)
- Биологийн мэдээлэл (амьтан, ургамлын бүлгэмдэл)
- Тухайн газарт явуулж буй аж ахуйн үйл ажиллагаа
- Газар, байгалийн баялгийн ашиглалт
- Дэд бүтэц /барилга байгууламж, замын сүлжээ, холбоо харилцаа, цахилгаан болон усан хангамж/
- Хамгаалалтын захиргааны талаарх бүрэн мэдээлэл, материаллаг бааз, орон нутагтай хэрхэн хамтарч ажилладаг талаархи мэдээлэл
- Нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, түүний онцлог
- Аялал жуулчлал, түүнээс үзүүлэх нөлөөлөл, онцлог
- Ирээдүйд ТХГН-т үзүүлэх хүчин зүйлийн нөлөөллийн талаар
- Байгаль орчны болон бусад холбогдох хууль эрхийн актууд
- Олон Улсын конвенц бусад хууль эрх зүйн актууд
- Тухайн орон нутагт хийсэн гэрээ, зөвшилцөл,
- Хил дамнасан ТХГ бол хоёр талын хамтарсан гэрээ, хэлцэл,
- Олон улсын хамтын ажиллагаа гэх мэт.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг мэдээлэл хангалтгүйн шалтгаанаар хойшлуулж болохгүй. Ийм нөхцөлд олдсон мэдээлэлд тулгуурлан энгийн төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад уг мэдээллийг бүрдүүлэн менежментэд уялдуулахаар үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж өгөх хэрэгтэй.

Мэдээлэл нь баталгаажаагүй, таамаглал дээр үндэслэгдсэн тохиолдолд авсан эх үүсвэрийг нэмэлт тайлбартайгаар оруулна. Газрын зургийг хавсралт хэлбэрээр оруулна.

3.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөг боловсруулах

Хүрсэн байх үр дүн:

- ТХНГ-ийн менежментийн алсын хараа, хамгаалах үнэт зүйлсүүдийг тодорхойлж эрэмбэлсэн байна.
- Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн байдал, тэдгээрт учирч буй аюул заналын үнэлгээ, ач холбогдлын дараалалыг тогтоосон байна.
- Менежментийн зорилго, зорилтуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна.

3.2.1. Алсын хараа тодорхойлох

Алсын хараа гэдэг нь тухайн ТХГ ирээдүйд ямар байх талаарх төсөөллийн товч тодорхойлолт юм.

Жишээлбэл:

Байгаль хамгаалах хамтын менежментийг сайжруулах замаар хялганат тал хээрийн экосистем, түүний түлхүүр зүйл болох Цагаан зээрийн болон бусад биологийн төрөл зүйлийн амьдрах орчин цогц байдлаар хамгаалагдсан нутгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна.

Энэ жишээн дээр ТХГ алс хэтдээ ямар үр дүнд ямар арга замаар хүрэх санааг агуулсан байна.

3.2.2. Хамгаалах үнэт зүйлсүүдийг тодорхойлох

ТХГН-ийн нэг үе шатны менежментийн төлөвлөгөөгөөр хамгаалах бүх үнэт зүйлсэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй юм.

Иймд ТХГ-ын **хамгаалбал зохих үнэт зүйлсийн гол төлөөлөл болох онцлог төрөл зүйлийг** сонгон авч менежментийн арга хэмжээний дарааллыг тогтоох нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх давуу талтай төдийгүй хэрэгжүүлэхэд боломжтой байдаг.

Олон улсын туршлагаард хамгаалах **8-10 үнэт зүйлсийг** сонгох нь тохиромжтой гэж үздэг. Зөв сонгон авсан, цөөн тооны хамгаалах үнэт зүйлсийг үр дүнтэй хамгаалах, зохистой ашиглахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулснаар одоогийн байдлыг хэвээр хадгалах, сайжруулахад менежментийн төлөвлөгөөний эцсийн зорилго оршино.

Хамгаалах үнэт зүйлсийг биологийн олон янз байдал болон түүх, соёлын өв гэж хоёр хуваан үзэж болно.

Биологийн олон янз байдал:

Хамгаалах биологийн янз байдлыг дараах 2 шаттайгаар сонгоно Үүнд:

Нэгдүгээрт: Тухайн ТХГН-т хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын жагсаалтыг гаргах. Үүнд тухайн газар нутгийн талаар мэдлэг бүхий судлаачид, мэргэжилтнүүдийг оролцуулан саналыг авна.

Хоёрдугаарт: Жагсаалтад орсон хамгаалах биологийн олон янз байдлаас хамгийн чухал байж болох 8-10 зүйлийг сонгоно. Хамгаалах олон янз байдлыг сонгохдоо дараах шалгууруудыг ашиглана Үүнд:

Экосистемийн шалгуурууд:

- Сонгож буй экосистем нь тухайн ТХГН-т зонхилдог байх,
- Тухайн экосистем нь экологийн хувьд харьцангуй бага хөндөгдсөн эсвэл нөхөн сэргээх боломжтой байх,
- Тухайн экосистемийг хамгаалж чадвал түүний далбаан дор нь бусад чухал зүйлүүдийг хамгаалах боломжтой байх,

Бүлгэмдэл, зүйлийн төлөөллийг сонгохдоо доорх шалгууруудыг баримтлана:

Тархацын царх хүрээ: ТХГ-ын хэмжээнд зах хязгаарын, алаг цоог, хязгаарлагдмал, уудам газар нутаг шаарддаг өргөн тархацтай гэх мэт.

Хамгаалалын төлөв байдал: Олон улсын байгаль хамгаалах холбоо(IUCN), Нүүдэллэдэг зүйлийг хамгаалах олон улсын конвенци (CMS)-ийн шалгуураар ховордлын зэрэг нь тогтоогдсон, мөн үндэсний хэмжээнд хуулиар хамгаалагдаж буй, Улаан номонд бүртгэгдсэн.

Аюул хөнөөлд өртөж байгаа байдал: Олон улсын болоод бүс нутгийн хүрээнд устаж болзошгүй, ховордож буй.

Экосистемд эзлэх байр суурь: Эндемик, илтгүүр, шүхэр зэрэг чухалчлах шинж чанартай.

Популяцийн тоо толгойн төлөв байдал: Урт удаан хугацааны турш тогтмол цөөрч байгаа, сүүлийн арван жилд популяцийн тоо толгой (1-30%, 31-50%, 51-70%, 71-100%-иар) буурч байгаа.

Эмзэг байдал: Одоогийн байдлаар тоо толгой нь буураагүй, элбэг тохиолдох боловч хязгаарлагдмал, өвөрмөц орчинд амьдардаг. , Тухайн орчин үгүй болоход шууд устах эмзэг шүтэлцэлд амьдардаг. Амьдарлынхаа аль нэг хугацаанд үржлийн, нүүдлийн гэх мэт хязгаарлагдмал, өвөрмөц орчинг шүтэж амьдардаг.

Экосистемийг төлөөлөх боломж: Тухайн ТХГ дахь экосистемийг төлөөлөх боломж.

Дэлхийн хэмжээний ач холбогдол зэргийг чухалчлан үзнэ.

Биологийн ба соёлын олон янз байдал:

ТХГ-ыг байгалийн бүс бүслүүрийн онцлог, ховор ховордсон амьтны тархац бүхий газраас гадна түүх, соёлын өвийг хадгалан, хамгаалах зорилгоор байгуулдаг. Нутгийн уугуул иргэдийн соёл, ёс заншлын олон хэлбэр, эрт үеэс уламжлагдсан ирсэн байгаль ба соёлын хооронд үүсч тогтсон гүн гүнзгий харилцаа, холбоог тооцолгүйгээр байгаль хамгаалах бодлогыг тодорхойлоход бэрхшээлтэй.

Мөн нутгийн иргэдийн шашин шүтлэг, уламжлалт зан үйл, түүхийн дурсгалтай холбоотой чухал газруудыг хамгаалах нь тухайн ТХГ-ын хамгааллын ач холбогдлыг өндөр болгох, олон нийтийн зүгээс дэмжлэг авахад чухал байдаг.

Энэ нь тухайн ТХГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдолтой тул тусгайлан анхаарч хамгаалах үнэт зүйлд оруулна. Иймд ТХГН-ийн онцлогоос шалтгаалж түүх, соёлын хувьд хамгийн чухал гэж үзсэн үнэт зүйлүүдийг сонгох нь зохистой.

3.2.3. Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх

Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийх нь менежментийн төлөвлөгөө боловсруулах хамгийн чухал алхамын нэг юм. Үнэлгээний гол зорилго нь байгаль, түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалахад тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн учир шалтгаануудыг тодорхойлоход оршино.

Энэ үнэлгээгээр ТХГН-ийг цаашид хөгжүүлэх боломжийг хязгаарлаж буй асуудлуудыг тодорхойлно. Дүн шинжилгээ хийхдээ ТХГ-ын хамгаалалтын захиргаад өөрсдийн бололцоонд тулгуурлан янз бүрийн арга хэрэглэж болно. Манай улсад өнөөдрийн байдлаар нийтлэг хэрэглэгдэж байгаа дараах 2 аргыг сонгож зөвлөмжинд оруулж байна.

1. Оролцооны арга: (Хөдөөгийн оролцоотой үнэлгээний (PRA) судалгаанд хэрэглэдэг зураглал, урсгал диаграмм, харьцуулал гэх мэт).
2. Байгаль хамгаалалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд (TNC, WWF, WCS, RARE FOS)-аас хамтран гаргасан байгаль хамгааллын үйл ажиллагааны төлөвлөлт хийх арга зүй MIRADI, CAP.

Дүн шинжилгээнд хэрэглэж буй дээрх хоёр аргын давуу болон сул талуудыг дараах байдлаар харуулав.

Аргууд	Давуу тал	Сул тал
Оролцооны арга (PRA)	<ul style="list-style-type: none"> - Талуудын оролцоог жигд хангана - Хэрэглэхэд энгийн, хялбар - Мэргэжлийн өндөр ур чадвар шаардахгүй - Компьютерийн программ шаардахгүй 	<ul style="list-style-type: none"> - Цаг хугацаа их шаардана - Зардал өндөр - Үнэлгээ магадлал өндөр биш - Мэдээллийн хадгалж архивлах боломж муу
Миради, CAP	<ul style="list-style-type: none"> - Программ ашигладаг тул үнэлгээнүүд хоорондоо уялдаа холбоо сайтай - Үнэлгээний магадлал өндөр - Мэдээллийг хадгалах, дахин сайжруулан ашиглахад илүү тохиромжтой 	<ul style="list-style-type: none"> - Компьютерийн тусгай программ шаардана - Боловсон хүчин мэрэгшсэн байх шаардлагатай - Хэрэглэхэд хялбар бус

Манай улсын ТХГ-уудад оролцооны арга PRA (Participatory Rural Appraisal) буюу 90-ээд оны дунд үеэс хэрэглэж ирсэн бөгөөд энэхүү аргыг хэрхэн ашиглах талаар гарын авлага, аргачлалууд тодорхой хэмжээгээр гарч байсан. Иймд зөвлөмжид оролцооны аргуудыг оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Харин шинэ тутам хэрэглэж буй байгаль хамгаалалын үйл ажиллагааны төлөвлөлт хийдэг гол аргын нэг болох MIRADI-г ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад хэрхэн ашиглах талаар хавсралтаар товчлон толилуулж байна.

Биологийн төрөл зүйлийн амьдрах чадварын үнэлгээ:

Биологийн олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээ гэдэг нь сонгон авсан экосистем, бүлгэмдэл, зүйлийн одоогийн байдал, цаашид тэдгээрийн оршин тогтноход нөлөөлөх гол хүчин зүйлсийн талаарх үнэлгээ юм. Үнэлгээний аргачлалыг 1-р хавсралтаар үзүүлэв.

Тулгамдсан аюул, дарамтыг тодорхойлох, эрэмбэлэх:

Хамгаалах биологийн олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээг тогтоосны дараах чухал алхам бол хамгаалах үнэт зүйлсэд тулгарч буй бэрхшээл буюу аюул заналыг тодорхойлж эрэмбэлэх асуудал юм. ТХГН-ийн менежментийн тодорхой зорилтуудыг дэвшүүлэхээс өмнө менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул заналыг тодорхойлж, шаардлагатай нөөц боломжийг тогтоох хэрэгтэй. Аргачлалыг 2-р хавсралтаар үзүүлэв.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ:

Хамгаалах үнэт зүйлсэд учирч буй дарамт, тэдгээрийг үүсгэж буй аюул занал, шалтгаануудыг задлан шинжлэх, улмаар тэдгээрийг шийдвэрлэхийн тулд тодорхойлсон үр дүнгүүдийг локиг дарааллаар тогтоох дүн шинжилгээ юм.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх аргачлал, жишээг 3-р хавсралтаар үзүүлэв.

3.2.3. Зорилго, зорилтууд ба түүний шалгууруудыг тодорхойлох, арга хэмжээг төлөвлөх


Зорилгоо тодорхойлох:


Зорилгодоо тухайн ТХГН-ийн менежментийн үйл ажиллагааг явуулснаар ирээдүйд ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг тусгана. Зорилго нь хамгаалах үнэт зүйлийг хэвээр хадгалан үлдэх, эсвэл өсгөн нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, тодорхой хугацааны дараа ТХГН ямар хөгжилд хүрэхийг тодорхойлохоос гадна хүмүүст тухайн газрыг хамгаалснаар ирээдүйд юуг хүсэн хүлээж байгааг ойлгоход тусладаг. Цаг хугацаа өнгөрсөн ч менежмент нь тогтвортой байх зарчмыг баримтална. Зорилго нь хэмжигдэхүйц шалгуурыг багтаасан байна.

Зорилтоо тодорхойлох:

Менежментийн төлөвлөгөөний зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тухайн хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтыг бууруулах, арилгахад чиглэгдсэн зорилтуудаа нарийвчлан тодорхойлно. Зорилтуудад хүрснээр тухайн хамгаалах үнэт зүйлийн зорилгуудад үр дүнгүүд гарах ёстой. Зорилтууд нь мөн хэзээ биелэх нь тодорхой, хэмжигдэхүйц байна. Үүний тулд зорилт тус бүрт шалгуур хийж өгдөг. Зорилтуудыг ойрын 2-3 жилийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөнө.

Дараах дүрст үр дүнгийн хэлхээ нь хэрхэн аюул заналыг бууруулах болон хамгаалах биологийн олон янз байдлын зорилготой холбогдох байдлыг харуулж байна. (Тайлбарыг Хавсралт, 4-т үзүүлсэн жишээнээс үзнэ үү)





Шалгууруудыг тодорхойлох:

Дээрх дүрст харуулсанчлан хэтийн зорилго, аюул заналыг бууруулах зорилго, зорилтуудын хувьд шалгууруудыг тус тусад нь тодорхойлох шаардлагатай.

Шалгуурыг сонгоход дараах зарчмуудыг баримтлана. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэл сайтай
- Гадны ямар нэг өөрчлөлтөд мэдрэмтгий (Өөрөөр хэлбэл тухайн үеийн онцлог нөхцөл байдлаас шалтгаалж менежментийн хэрэгжилтэнд үзүүлж болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг тооцох Ж. нь ган, зуд, ой хээрийн түймэр, санхүүжилт гэх мэт)
- Өөрчлөлт гарч буй талаар дохиолол өгч чадахуйц (*Тодорхой цаг хугацаанд тоо болон чанарын өөрчлөлт гарч буйг харуулж чадахуйц*)
- Түгээмэл хэрэглэгддэг, нарийвчлал сайтай арга зүйг ашиглах
- Өртөг зардлын хувьд хямд байх г.м

Шалгуурууд нь тухайн зорилго, зорилтуудад ахиц дэвшил гарч буй эсэхийг харуулж чадахуйц үзүүлэлт байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх:

Үр дүн дээр тулгуурласан зорилтуудыг тодорхойлсны дараагаар зорилт тус бүрт хүрэх арга хэмжээг төлөвлөнө. Үйл ажиллагааг жил жилээр төлөвлөх ба энэ нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөний үндэслэл болно. Хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх схем, хүснэгтийг 4-р хавсралтанд үзүүлэв

3.2.4. Менежментийн төлөвлөлгөөг хэрэгжүүлэх чадавхийг төлөвлөх

Менежментийн зорилго, зорилтуудад хүргэх үйл ажиллагаанд шаардагдах хүний нөөц, чадавх, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг төлөвлөх нь дараагийн гол алхам болно. Төлөвлөх хүснэгтийн жишээг 5-р хавсралтын 1- 4-р хүснэгтэд үзүүлэв.

Тусгай хамгаалалттай газрууд нь үүнээс гадна урт бизнес төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Урт хугацааны санхүүжилтийн төлөвлөлтийг бизнес төлөвлөгөөнд тусгаж болно. Энд

зөвхөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг гаргахад ашиглаж болох загварыг 5-р хүснэгтээр харууллаа.

3.2.5. Мониторингийн төлөвлөгөө

Хамгаалах биологийн олон янз байдлын хувьд мониторинг хийхдээ амьдрах чадварын үнэлгээний хэсэгт тогтоосон шалгууруудыг ашиглана. Үнэлгээний хүснэгтийн загварыг 5-р хүснэгтээр харуулав.

3.3. Менежментийн төлөвлөгөөний эхний хувилбарыг боловсруулж олон нийтээр хэлэлцүүлэн санал авах

Хүрсэн байх үр дүн:

- Менежментийн төлөвлөгөөний анхны хувилбар буюу эх ноорог бэлэн болсон байна.
- Менежментийн төлөвлөгөөний хэтийн зорилго, зорилтууд, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гол үйл ажиллагааны талаар оролцогч талуудад санал, шүүмж өгөх боломжийг олгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Менежментийн төлөвлөгөөний үндсэн мэдээллийн хэсэгт орох материал, тоо баримтыг нэгтгэнэ.
- Цуглуулсан мэдээллүүдэд хийсэн дүн шинжилгээний материалыг эмхэтгэнэ.
- МТ-ний эхний хувилбарыг нэгтгэж бичиж олон нийтийн санал авах ажлыг зохион байгуулна. Үүний тулд:
 - Орон нутагт уулзалтуудыг зохион байгуулах (сум багийн хурал, олон нийтийг хамарсан арга хэмжээг ашиглах)
 - Тусгайлсан семинар, зөвлөгөөн зохион байгуулах
 - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах,
 - Цахим сүлжээ буюу интернет ашиглах
 - Хялбаршуулсан танилцуулга, эвхмэл хуудас хэвлүүлж тараах гэх мэт

Менежментийн төлөвлөгөө бичих арга барил, хэлбэр

Менежментийн төлөвлөгөөг нь шинжлэх ухааны нарийн нэр томъёо хэрэглэхээс зайлсхийсэн, олон нийт болон мэргэжлийн бус хүн ойлгохоор, ТХГН-ийн үнэ цэнэ, ач холбогдолыг хүн бүрт хүргэсэн, түүний хэрэгжилтэнд олон нийтийн дэмжлэг авахуйц хэлбэрээр бичигдсэн байх хэрэгтэй. Сайн боловсруулсан менежментийн төлөвлөгөө нь дараахь шинж чанарыг агуулсан байна. Үүнд:

- Тодорхой бөгөөд хүн бүрт ойлгомжтой,
- Товч хураангуй, мэдээлэл сайтай, агуулга нь асуудлаа бүрэн хамарсан
- Зорилго, зорилтуудаа тодорхой дэвшүүлсэн,
- Системтэй, логик дэс дараатай,
- Оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрсөн, тэднийг уриалан дуудсан шинжтэй,
- Бодитой, хэмжиж болохуйц зорилтуудтай, түүндээ хүрэх арга зам нь тодорхой, үр дүнг нь хянан үнэлэх боломжтой,

- Гол асуудалдаа төвлөрсөн, үр өгөөжтэй,
- ТХГН-ийн зохистой менежментийн гол арга хэрэгсэл болоход чиглэгдсэн.

3.4. Менежментийн төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж батлуулах

Хүрсэн байх үр дүн:

- Менежментийн төлөвлөгөөг ажлын хэсгээр эцэслэн боловсруулж дууссан байна.
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага баталсан байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Сонирхогч талууд, ард иргэдээс гарсан саналыг дахин хянасны үндсэнд төслийг сайжруулж, менежментийн төлөвлөгөөний эцсийн хувилбарыг боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.
- Төлөвлөгөөг танилцуулга маягаар иргэдэд тарааж болно. Мөн тухайн ТХГ өөрийн вэб сайтдаа оруулж нийтэд хүртээмжтэй, ил тод байлгана.
- Менежментийн төлөвлөгөөг ТХГН-т хамрагддаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн /Тэргүүлэгчдийг/ хурлаар, хэрвээ хэд хэдэн сумын нутгийг хамран хийгдэх нөхцөлд тухайн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн /Тэргүүлэгчдийн/ хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн байх.
- Бэлэн болсон менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянан батлана.

Дөрөв. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх механизм

Менежментийн төлөвлөгөөний биелэлт нь төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтэд заагдсан үр дүнд хүрснээр хангагдана. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө нь хамгаалалтын захиргаа, тухайн орон нутгийн төр, захиргааны болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхэн, иргэний нийгмийн байгууллагууд, ТХГН болон түүний орчны бүсэд амьдардаг малчид, нутгийн иргэдийн нягт хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжинэ.

Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг биелүүлэхэд орон нутгийн төр захиргааны байгууллага, ард иргэдийг идэвхтэй татаж оролцуулах нь хамгаалалтын захиргааны ажлын арга барил, зохион байгуулалтаас ихээхэн хамаарна.

Хамгаалалтын захиргаа нь ТХГН-т үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд, бүлэг, нөхөрлөлүүд болон орон нутгийн захиргаадыг мэдээллээр хангах, харилцан мэдээлэл солилцох замаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

Мэргэжлийн боловсон хүчнийг зөв сонгож, байршлыг зөв тогтоох, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үр ашигтай ашиглах зэрэг нь хэрэгжилтийг хангах нэг үндэс болно.

Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрүүд болон бусад хөрөнгө оруулагчдын хандив тусламжийг зохистой хослуулах хэрэгтэй.

Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн зардлыг төсөвт нарийвчлан суулгаж, улсын төсвөөс хуваарилуулж авах ажлыг нэн түрүүнд зохион байгуулах шаардлагатай.

Менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан жил бүр бие даасан төлөвлөгөө гаргана.

Менежментийн төлөвлөгөөг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Хамгаалалтын захиргаа жил бүрийн ажлын төлөвлөгөөг боловсруулж БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.
- ТХГН-ийн Хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан томоохон зорилтуудыг БО-ны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ТХГН-ын асуудал хариуцсан газрын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулна.
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд олон улсын болон шинжлэх ухааны байгууллагуудын дэмжлэг тусалцааг авахын тулд хамгаалалтын захиргаанаас эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулан ажиллана.
- Менежментийн арга хэмжээг хамтран гүйцэтгэх талуудаас шаардагдах төсөв хөрөнгийг тухайн байгууллагуудын санхүүгийн төлөвлөгөөнд жил бүр тусгуулахад тухайн ТХГ-ын Хамгаалалтын захиргаа идэвхи, санаачлага гарган ажиллах.
- Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд орон нутагт шийдэх бололцоотой ажлуудыг санхүүжүүлэх асуудлаар аймгийн ИТХ, Засаг даргад санал оруулан шийдвэрлүүлж төсөвт нь тусгуулахад тухайн ТХГ-ын Хамгаалалтын захиргаа идэвхи, санаачлага гарган ажиллах.
- Шаардлагатай ажлыг санхүүжүүлэх асуудлаар төсөл боловсруулан холбогдох газруудад танилцуулах замаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- Менежментийн төлөвлөгөөг дагалдсан дэд хөтөлбөрүүдийг (Газар, аялал жуулчлал, Ой, Бэлчээр, Соёлын өв, Дэд бүтэц гэх мэт) боловсруулан, хэрэгжилтийг хангуулна.

Менежментийн төлөвлөгөөны хэрэгжилтийг хангах асуудал нь ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажил үүрэгт хамаарах бөгөөд төсвийн байгууллагын санхүүжилтийн хуулийн дагуу тухайн жилийн үр дүнгийн гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг зөв оновчтой тодорхойлж тусгасан байна.

Хамгаалалтын захиргаа жил бүр менежментийн төлөвлөгөөг үндэслэн бизнес төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг байна.

Бизнес төлөвлөгөөний гол зорилго нь хамгаалалтын захиргааны санхүүгийн өнөөгийн болон ирээдүйн төлөвийг тодорхойлж, тухайн жилийн хөрөнгө оруулалт, менежментийн үйл ажиллагааны урьдчилсан зардлыг тооцон гаргаж, тогтвортой санхүүжилтийн механизмыг буй болгоход оршино.

Бизнес төлөвлөөний гол зорилтууд нь дараах асуудлуудад чиглэгдсэн байна. Үүнд:

- Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлэх.
- Менежментийн төлөвлөгөөний дагуу нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудад ач холбогдлын дэс дараалал тогтоох.
- ТХГ-ын өнөөгийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, санхүүг тогтвортой байдалд хүрэх стратегийн талаарх мэдээллийг оролцогч талуудад хүргэх.
- ТХГ-ын тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэх сонирхол бүхий хандивлагчдыг холбогдох материалаар хангах.

Тав. Менежментийн төлөвлөгөөний үнэлгээ ба мониторинг

Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах, хяналт тавих, үр дүнг тооцох ажлыг хамгаалалтын захиргаа, менежментийн зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

- Хамгаалалтын захиргааны хувьд менежмент төлөвлөгөөний хэрэгжилтэнд хагас жил тутам мониторинг хийнэ.
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэн үнэлж, дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах суурь болгоно.
- Менежментийн төлөвлөгөө хэрэгжилтэд хяналт тавихын тулд төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудын шалгуур үзүүлэлтэнд дурьдсан үр дүнгээр үнэлнэ.
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тодорхой шалтгааны улмаас төлөвлөгөөнд оруулах шаардлага гарвал Менежментийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- Жил бүрийн хэрэгжилтийн явцын үнэлгээний тайланг БОАЖЯ-нд тайлагнана.
- Тухайн жилийн тайлан, дүгнэлтийг дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг үндэсний болон олон улсын байгууллагуудад хүргүүлж цаашид хамтран ажиллах чиглэл, төсөвийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн бүрэн үнэлгээг 4 жил тутам мэргэжлийн багаар гүйцэтгүүлж дүгнэлт гаргуулна.
- ТХГН-ийн менежментийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусах жилд дараа үеийн төлөвлөгөөг боловсруулж эхэлнэ.
- Шаардлагатай тохиолдолд ТХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд олон улсад мөрдөгдөж буй нийтлэг зарчим, арга зүйн хүрээнд хөндлөнгийн АУДИТ үнэлгээ өгч болно.

Үнэлгээний шалгууруудыг ашиглах

Менежментийн төлөвлөгөөний үнэлгээ, мониторинг хийхэд зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах шалгууруудыг үндэслэнэ.

Менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг /мониторинг/ ямар ажил хийснээр нь бус менежментэд ямар өөрчлөлт, ахиц дэвшил гарав гэдгийг гол шалгуур болгоно. Тухайлбал:

- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ТХГН-ийн ландшафтын унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал хэр зэрэг хадгалагдаж байгаад болон ховор амьтны популяци, ургамлын бүлгэмдэл зэрэгт гарсан өөрчлөлт,
- Байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалтын байдалд гарсан өөрчлөлт нь менежментийн төлөвлөгөөний зорилтыг ханган биелүүлэх шаардлагын хэмжээнд хүрч байгаа эсэх,
- Хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо сайжирснаар менежментийн хувьд ямар ахиц гарав,
- Бүлэг, нөхөрлөлүүд ба нутгийн иргэд хэрхэн чадавхижсан, байгаль хамгааллын ажилд хэр зэрэг идэвхитэй оролцдог болсон,
- Аялал жуулчлал нь тавигдаж буй шаардлага, зарчимд хир зэрэг нийцтэй болсон, энэ нь иргэдийн амьжиргаанд ямар нөлөө үзүүлж байгаа,
- ТХГН-т иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын маршрут бий болж, гадаад дотоодын аялагчдын тоо нэмэгдсэнээр нутгийн иргэд, малчдад аялал жуулчлалаас орох орлого хэрхэн нэмэгдсэн,
- Орон нутгийн удирдлага, ард иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, экологийн мэдлэг, боловсрол олгох сургалтууд зохион байгуулснаар ямар үр дүнд хүрэв,
- Хууль бус үйлдлийг зогсоосон арга хэмжээ нь олон нийтэд хүмүүжлийн үр нөлөө өгөхүйц болж чадсан эсэх,
- Орон нутгийн захиргаад аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага, иргэдэд байгаль орчны асуудлаар мэдээлэл сурталчилгааны ажил хийснээр хамтын ажиллагаа, хамгаалалтын менежментэд оролцох оролцоо хэрхэн сайжирсан гэх мэт.

Зургаа. Бусад хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулах нь

ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенцууд, Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр / УИХ, 1996/, “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр” УИХ 1998/, “Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” / УИХ, 2008/, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал,”/ УИХ, 2010/, “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”/УИХ, 1998/ зэрэг урт хугацаны баримт бичгүүдийн бодлого, үзэл санаатай уялдсан байх шаардлагатай.

ТХГН нь тодорхой бүс нутагт, засаг захиргаа, нутаг дэвсгэрээс хамааралтай, нутгийн иргэдийн хүрээлэл дунд оршдог тул менежментийн төлөвлөгөө нь:

- Бүс нутгийн болон аймаг, сумын хөгжлийн хөтөлбөр,
- ТХГН-ийн Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө,

- Тухайн орон нутгийн ХАА, Газрын харилцаа, БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудын бодлого, хөтөлбөр,
- ТХГН-ын хил залгаа болон хилийн дотор байрладаг нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, цэргийн анги нэгтгэлүүдийнг байгаль орчны үйл ажиллагаа зэрэгтэй нягт уялдсан байна.

Монгол орны хувьд ТХГН-ийн тогтвортой байдал нь тухайн бүс нутгийн иргэдийн амьжиргаатай шууд хамааралтай. Иймд ТХГН-ийн менежментийн болон орчны бүсийн төлөвлөгөө боловсруулахад нутгийн иргэдийн оролцоо, тэдний дэмжлэг маш чухал. 1998 онд батлагдсан ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль энэ талын эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн.


Менежментийн төлөвлөгөө нь ТХГН-ийн талаархи хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээний ажил явуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, газар болон бэлчээр ашиглалтыг зохицуулах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, байгууллагынхаа чадавхийг бэхжүүлэх зэрэг Монгол улсын ТХГН-ийн Үндэсний хөтөлбөрт /1998/ тусгагдсан өргөн хүрээтэй зорилтуудтай уялдсан байна.

Долоо. Хавсралтууд.

1-р хавсралт

Биологийн олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээ.

Байгаль хамгааллын үйл ажиллагааг төлөвлөхөд ашигладаг MIRADI арга зүйн ерөнхий схем



Биологийн олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээг дараах үе шаттайгаар хийнэ. Үүнд:

1. Экологийн чухал хүчин зүйлсийг тогтоох, сонгох
2. Эдгээр хүчин зүйлийн хувьд ашиглах шалгуур үзүүлэлтийг тогтоох
3. Шалгуур үзүүлэлтүүдийг ангилах

Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдлын одоогийн байдлыг тогтооход “**Экологийн чухал хүчин зүйл**” гэдэг ухандахууныг ашигладаг бөгөөд энэ нь тухайн биологийн олон янз байдлын оршин тогтноход зайлшгүй чухал болох зүйлийн амьдралын мөчлөг, популяцийн бүтэц, зүйлийн бүрдэл, амьд болон амьгүй хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэл зэрэг нөхцлүүд юм.

Өөрөөр хэлбэл эдгээр зайлшгүй экологийн чухал хүчин зүйлс устах буюу доройтох аваас тухайн хамгаалах биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлөх тийм хүчин зүйлүүд (популяцийн бүтэц алдагдах, тоо толгой буурах гэх мэт) гэж ойлгож болно.

Экологийн чухал хүчин зүйл нь хамгаалах биологийн олон янз байдлын бүтэц, бүрэлдэхүүн, хэвийн үйл ажиллагааг биологийн болон газар зүйн янз бүрийн хэмжээст ойлгох, хэмжихэд чухал ач холбогдолтой юм.

Экологийн чухал хүчин зүйлийг дараах 3 ангилалд хувааж үзнэ. Үүнд:

Хэмжээ: - Экосистемийн хамрах хүрээ, зүйлийн тоо, толгой гэх мэт биологийн олон янз байдлыг хэмжих ойлголт. Мөн тухайн популяци дахь бодгалийн тоо, популяцийн оршин тогтнох хамгийн бага динамик газар нутгийн хэмжээ байж болно.

Нөхцөл: гэдэг нь тухайн биологийн олон янз байдлын бүтэц, бүрэлдэхүүн, бусад амьд организмтай харилцан үйлчлэлд орох нөхцлүүдийг хэлнэ.

Ландшафтын хүчин зүйл: Тухайн хамгаалах олон янз байдлын оршин тогтноход чухал нөлөөтэй хүрээлэн буй орчны экологийн горим, үйл явц ба холбогдох байдал.

Энэ нь тухайн нэг амьтны зүйлийн хувьд амьдралын мөчлөгийг гүйцээхэд шаардлагатай амьдрах орчиндоо нүүдэллэн очих боломж, экологийн бүлгэмдэл ба системийн хуваагдал, зүйлийн тархах, нүүдэллэх, дахин колончлох үйл явцыг бүрдүүлж чадах тухай ойлголт юм.

Экологийн чухал хүчин зүйлийн зарим жишээг дараах хүснэгтэд харуулав:

Экологийн чухал хүчин зүйлийн зарим жишээ

Ангилал	Экологийн чухал хүчин зүйл
Хэмжээ	Популяцийн хэмжээ ба динамик
	Экосистем дэх чухал бүлгэмдлүүдийн хэмжээ эсвэл сукцессийн шат
	Голлох экосистем, амьдрах орчин, бүлгэмдлийн тоо хэмжээ
Нөхцөл	Хоол тэжээлийн олдоц
	Бүлгэмдлийн бүтэц
	Махчлал болон шимэгчлэх
	Тоос хүртээх
	Популяцийн бүтэц ба сэлбэгдэл
	Түлхүүр зүйл болон харилцан үйлчлэлд ордог зүйлүүд байгаа эсэх
	Зүйлийн бүрдэл – зонхилол
	Сукцессийн динамик
Ландшафт-ын хүчин зүйл	Бүлгэмдлүүд болон экосистемүүд хоорондоо холбогдох байдал
	Түймрийн горим – цаг хугацаа, давтавж, эрчим, хамрах хүрээ
	Усны горим – улирлын өөрчлөлт, цаг хугацаа, үерийн давтамж, хамрах хүрээ
	Ландшафтын хэв шинж (алаг цоог байдал), бүтэц
	Тэжээлийн бодисын хуримтлал ба динамик

Ангилал	Экологийн чухал хүчин зүйл
	Хөрс, хурдсын суурь байдал ба нүүх хөдөлгөөн-угаагдал
	Хөрс хурдсын бүтэц, ба химийн найрлага
	Ус-хөрсний хэм
	Усны химийн найрлага
	Усны түвшингийн хэлбэлзэл
	Цаг агаарын горим – улирал, үргэлжлэх хугацаа, эрчим, цар хүрээ

Экологийн чухал хүчин зүйлд шалгуур тогтоох

Шалгуурыг экологийн чухал хүчин зүйлийн өнөөгийн төлөв ямар байгааг үнэлэхэд ашиглана. Экологийн чухал хүчин зүйл тус бүртээ шалгуур үзүүлэлттэй байж болно.

Жишээ нь: Голын усны химийн найрлага гэсэн экологийн чухал хүчин зүйлийг авч үзье:

Энэ тохиолдолд тухайн голын усны найрлагад байгаа бүх химийн бодисыг хэмжих боломжгүй тул төлөөлөл болж чадахуйц цөөн тооны гол бодисын хэмжилт хийх замаар тухайн голын усны химийн горим хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлж болно.

Иймд шалгуур гэдэг нь экологийн чухал хүчин зүйл хэрхэн өөрчлөгдөж байгаа мэдээллийг бидэнд өгч чадахуйц багц эсвэл нэг хэмжигдэхүүн байна.

Шалгуурыг зөв тогтоох нь хамгаалах зүйлийн талаар удаан хугацааны тандалт хийх, хамгаалах арга хэмжээ нь хэр үр дүнтэй байгааг тогтооход чухал ач холбогдолтой.

Шалгуурыг ангилалд оруулах:

Экологийн чухал хүчин зүйлийг хэмжих зөв шалгуурыг сонгон авч ангилалд оруулна.

Үүнийтулд байгалийн жам ёсны хэлбэлзлийг суурь үзүүлэлт болгон хэрэглэнэ:

- Хамгаалах биологийн олон янз байдлын одоогийн байдал ямар байна,
- ямар үед хэвийн бус байна гэж үзэх үү,
- ямар байвал зохих вэ зэрэг асуултуудад хариулахад туслана.

Өөрөөр хэлбэл, байгалийн жам ёсны хэлбэлзлээс хэтэрч байвал тухайн хамгаалах үнэт зүйлсийн байдлыг хэвийн хэмжээнд бус гэж үзэн хэвийн хэмжээнд байлгах зорилгоор менежментийн арга хэмжээг чиглүүлэхэд энэ аргын гол давуу тал оршино.

Энэ аргын хялбарчилсан жишээг дор тайлбарлав. Үүнд:

Байгалийн жам ёсны хэлбэлзэл:

- **Маш сайн:** Экологийн хувьд байх ёстой төвшин, сайжруулах бараг шаардлагагүй
- **Сайн:** Хэлбэлзэл нь зөвшөөрөгдөхүйц хэмжээнд байгаа. Менежментийн зарим арга хэмжээ авах шаардлагатай

- **Дунд:** Хэлбэлзэл нь зөвшөөрөгдөхүйц хэмжээнээс их болсон. Зайлшгүй хамгаалах арга хэмжээ шаардагдана.
- **Муу:** Нөхөн сэргээхэд маш хэцүү болсон. Устах аюулд орсон

Энэ аргыг хэрэглэх өөр нэг давуу тал нь менежментийн төлөвлөлт хийж байгаа хүмүүс эхний шатанд тухайн хамгаалах үнэт зүйлийн талаар таамаг мэдээлэлтэй байхад хангалттай. Судалгааны үндсэнд найдвартай мэдээлэлтэй болсноор энэ хэмжигдэхүүнийг сайжруулан засч байх боломжтой.

Хамгаалах олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээг нэгтгэн дор хүснэгтээр харуулав. Төлөвлөлтийн баг нь Мирази программыг ашиглах боломжгүй бол MS Word эсвэл MS Excel программаар ердийн хүснэгт ашиглан хийж болно.

Амьдрах чадварын үнэлгээ хийснээр тухайн хамгаалах биологийн олон янз байдлын одоогийн байдал, ирээдүйд хүрэх зорилгыг тодорхойлох боломжтой болно. Шалгууруудыг тухайн хамгаалах биологийн олон янз байдлын талаар мониторинг хийхэд ашиглана.

Хүснэгт . Амьдрах чадварын үнэлгээ:

				Шалгуурын ангилал Bold=Одоогийн байдал <i>Italics=хүсч буй үр дүн</i>			
Хамгаалах зүйл	Хэмжигдэхүүн	ЭЧХЗ	Шалгуур	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Тарвага	Хэмжээ	Тоо толгой	Идэвхитэй нүхний тоо	<200	200-500	<i>500-1000</i>	1000<

Хүснэгтэд одоогийн байдлыг хэрэв ДУНД гэж үнэлсэн бол зорилт нь САЙН эсвэл МАШ САЙН болгоход оршино. Дээрх жишээнд одоогийн байдлыг тод хараар тэмдэглэсэн буюу 200-500 байна. Тэгвэл хамгаалах зорилго нь тарваганы идэвхитэй нүхний тоог 500-1000 болгох байж болно. Ингэхдээ хэдэн онд ийм зорилтод хүрэхийг зааж өгнө. Энэ зорилго нь менежментийн хүрэхийг зорьж буй эцсийн зорилго байх бөгөөд тодорхой цаг хугацаатай, хэмжигдэхүйц байх ёстой.

Жишээ: 2015 он гэхэд тус газарт тарваганы идэвхитэй нүхний тоо 500-1000 болсон байна.

Зорилгод хүрч буй эсэхийн шалгуур нь амьдрах чадварын үнэлгээний хэсэгт тогтоосон экологийн чухал хүчин зүйлийн шалгуурууд байх болно. Энэ тохиолдолд шалгуур нь тарваганы идэвхитэй нүхний тоо байх бөгөөд мониторинг үнэлгээг тарваганы идэвхитэй нүхийг тоолох замаар хийнэ.

Хамгаалах үнэт зүйл тус бүрээр ийм аргаар амьдрах чадварын үнэлгээг гаргасны дараа нийт хамгаалах биологийн олон янз байдлын нийлбэр үнэлгээг гаргаж болно. Миради эсвэл CAP программыг ашиглах, боломжгүй бол энгийн хүснэгт ашиглан хийж болно. Жишээг дор харуулав.

Биологийн олон янз байдлын одоогийн үнэлгээ

Хамгаалах үнэт зүйлс		Ландшафт	Нөхцөл	Хэмжээ	Одоогийн байдлын нийлбэр үнэлгээ
1	Хялганат хээрийн экосистем	Дунд	Сайн	Дунд	Дунд
2	Тарвага	Дунд	Маш сайн	Дунд	Дунд
3	Үнэг	Муу	Сайн	Муу	Муу
Биологийн эрүүл байдлын ерөнхий үнэлгээ					Дунд

Хамгаалах биологийн олон янз байдлын ерөнхий үнэлгээ нь тухайн ТХГ-ын одоогийн байдал ямар байгааг харуулна. Энэ үнэлгээг хийхэд Миради эсвэл CAP программ ашиглах нь давуу талтай. Энгийн хүснэгт ашиглаж байгаа тохиолдолд гурван үнэлгээний нийлбэрийг гаргах нь хүндрэлтэй. Энгийн хүснэгт ашиглахад дараах итгэлцүүрийг ашиглаж болно.

Үнэлгээний нэгдсэн дүнг тооцох:

- Хоёр үнэлгээ ижил байвал тэр үнэлгээг нийлбэр болгох. Жишээ: 2 Дунд, 1 Сайн бол Дунд гэж тооцох

- Гурван өөр үнэлгээ байгаа тохиолдол хамгийн муу үнэлгээ нь ерөнхий үнэлгээ болно. Жишээ: 1 Сайн, 1 Дунд, 1 Муу байвал Муу гэж тооцно.


2-р хавсралт

Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, эрэмбэлэх

Хамгаалах үнэт зүйлсэд тулгарч буй бэрхшээл буюу аюул заналыг тодорхойлж эрэмбэлэх нь дарамт ба дарамтын шалтгааныг тогтоохоос эхэлнэ.

Дарамтыг тогтоох, үнэлэх:

Дарамт гэдэг нь экологийн чухал хүчин зүйлүүдийн аль нэгийг доройтуулж буй тэр үйл явц юм. Жишээ нь Экосистемийн хуваагдал, Ургамлын нөмрөг муудах, тоо толгой буурах гэх мэт.



Дарамт нь тодорхой шалтгааны улмаас буй болж байгаль хамгаалал болон байгалийн нөөц баялагт /Ж нь тухайн хамгаалах биологийн олон янз байдалд / бэрхшээл буюу аюул заналыг бий болгоно. Аюул занал нь хамгаалах биологийн олон янз байдлын аль нэг экологийн чухал хүчин зүйлийг доройтуулах шалтгаан болж байдаг. Дарамтыг ноцтой байдал, хамрах хүрээг нь харгалзан хоёр ангилж тус тусад нь дараах байдлаар эрэмблэн үнэлнэ Үүнд:

Ноцтой байдал:

- **Маш их:** нөлөөлөл нь тухайн хүчин зүйлийг бүр устгах аюултай
- **Их:** ноцтой нөлөөлөл үзүүлэх
- **Дунд:** нөлөөлөл дунд зэрэг
- **Бага:** бага зэргийн нөлөөтэй

Хамрах хүрээ:

- **Маш их:** маш өргөн хүрээтэй
- **Их:** өргөн хүрээтэй
- **Дунд:** зарим газарт нөлөөтэй
- **Бага:** төдийлөн их тархасан биш

Дарамтын үнэлгээг мөн хүснэгтэд оруулан хийж болно. Боломжтой бол Мирази эсвэл CAP программыг ашиглах нь зүйтэй. Жишээ:

Хүснэгт: Дарамтын үнэлгээ

Дарамт	Ноцтой байдал	Хамрах хүрээ	Нийлбэр үнэлгээ
1. Популяцийн тоо толгой буурах	Их	Бага	Дунд
2. Зүйлийн бүрдэл өөрчлөгдөх	Их	Дунд	Их
3.			


Мирази эсвэл CAP программыг ашиглаж байгаа тохиолдолд нийлбэр үнэлгээг программ автоматаар тооцож гаргадаг. Хэрэв энгийн хүснэгт ашиглаж байвал дараах итгэлцүүрийг ашиглаж болно.

Дарамтын ерөнхий үнэлгээг тооцох:

- Хоёр дараалсан үнэлгээний аль багыг нь ерөнхий үнэлгээ болгон авах. Жишээ: Их ба Дунд байвал нийлбэр үнэлгээ нь Дунд байна.
- Хоёр үнэлгээний дунджаар авах. Их ба Бага гэсэн үнэлгээ байвал ерөнхий үнэлгээ нь Дунд болно. Маш их ба Бага байвал үнэлгээ нь Дунд байна.

Бэрхшээл буюу аюул заналын үнэлгээ

Дарамтын шалтгаан нь дарамтыг үүсгэж буй шууд хүчин зүйлүүд мөн бөгөөд бидний нэрлэж хэвшсэнээр аюул занал юм. Жишээ нь: Хулгайн ан, ойн түймэр гэх мэт



Аюул заналыг мөн оруулж буй хувь нэмэр, залруулах боломж гэсэн хоёр ангилалаар эрэмблэн үнэлж болно. Ингэхдээ дараах үнэлгээг ашиглана Үүнд:

Нөлөөллийн зэрэг:

- Маш их: Маш ихээр нөлөөтэй
- Их: Ихээхэн нөлөөтэй
- Дунд: Төдийлөн их биш бол
- Бага: Бага нөлөөтэй

Залруулах боломж:

- Маш их: Ямар ч аргаар залруулах боломжгүй
- Их: Залруулах боломжтой боловч маш их зардалтай
- Дунд: Байгаа хөрөнгө мөнгийн хэмжээнд залруулах боломжтой
- Бага: Хямд зардлаар амар хялбар залруулах боломжтой

Хүснэгт: Аюул заналын үнэлгээ:

Аюул занал	Нөлөөлөл	Залруулах байдал	Ерөнхий үнэлгээ
1. Хулгайн ан	Их	Бага	Дунд
2. Бэлчээрийн даац хэтрэх	Их	Дунд	Их
3.			

Миради эсвэл CAP программыг ашиглаж байгаа тохиолдолд нийлбэр үнэлгээг программ автоматаар тооцож гаргадаг. Хэрэв энгийн хүснэгт ашиглаж байвал аюул заналын нийлбэр үнэлгээг тогтоохдоо дараах итгэлцүүрийг ашиглаж болно.

Аюул заналын нийлбэр үнэлгээг тооцох:

- Хоёр дараалсан үнэлгээний аль багыг нь ерөнхий үнэлгээ болгон авах. Жишээ: Их ба Дунд байвал ерөнхий үнэлгээ нь Дунд байна.
- Хоёр үнэлгээний дунджаар авах. Их ба Бага гэсэн үнэлгээ байвал ерөнхий үнэлгээ нь Дунд болно. Маш их ба Бага байвал ерөнхий үнэлгээ нь Дунд байна.

Бэрхшээлүүдийг /аюул заналын зэргээр нь эрэмбэлэх

Бэрхшээлийг аюул заналыгн зэргээр нь хамгаалах зүйл тус бүрээр үнэлсний дараа нэгдсэн дүнг нэгтгэн гаргана. Нэг аюул занал нь хэд хэдэн биологийн олон янз байдалд нөлөөлж болно.

Хэрэв программ ашиглах боломжгүй бол хүснэгт ашиглан аюул заналын нийлбэр үнэлгээг гаргана. Хүснэгтэд Маш их аюул заналыг улаанаар, Их бол шараар, Дунд бол тод ногооноор гэх мэт тэмдэглэсэн байна. Өнгөөр ингэж ялгаж өгөх нь анхаарал хандуулахад хялбар болгоно.

Хүснэгт: Аюул заналын нийлбэр үнэлгээний жишээ:

Хамгаалах биологийн олон янз байдал		Хялгана т хээр	Тарвага	Цагаан зээр	Шонхор	Махчид	Аюул заналын нийлбэр
Бэрхшээл/аюул занал							
1	Бэлчээрийн даац хэтрэх	Их	Их	Их	Бага	Их	Их
2	Хууль бус ан	Их	Их	Их	Дунд	-	Их
3	Түймэр	Их	Их	Их	-	-	Их
4	Их хэмжээний хадлан бэлтгэх	-	Дунд	Их	-	Их	Их
5	Уул уурхай	-	-	-	Бага	Дунд	Дунд

6		-	-	-	-	Дунд	Дунд
7		-	-	-	-	Дунд	Дунд
Нийт аюул занал		Их	Их	Их	Дунд	Их	Маш их

- Аюул заналын нийлбэр үнэлгээг Миради болон CAP программыг ашиглан автомтаар тооцно.
- Хэрэв эдгээр программыг ашиглах боломжгүй бол энгийн байдлаар нэмэн хамгийн олон давтагдсан үнэлгээг нийлбэр үнэлгээ болгон тооцож болно.
- биологийн төрөл зүйлийн одоогийн байдал, амьдрах чадвар, дарамт, бэрхшээл, аюул заналын үнэлгээ зэргийг тооцож эрэмбэлэх эдгээр аргачлалууд нь MS Word, MS Excel программууд дээр үнэлгээний дундаж гаргахад хүндрэлтэй байна гэж үзвэл харгалзах оноо /балл өгч дүгнэж болно.
- Нийлбэр үнэлгээг тооцож гаргаснаар тухайн ТХГ-т ямар аюул занал хамгийн их нүүрлэж буйг тогтоох боломжтой.
- Менежментийн арга хэмжээг бүх аюул заналыг бууруулахад биш харин зөвхөн их буюу маш их гэж үнэлэгдсэн аюул заналыг бууруулахад чиглүүлнэ. Энэ нь хөрөнгө, мөнгө, цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой.

ТХГ-ын менежментийн дунд хугацааны зорилго нь эдгээр аюул заналыг бууруулахад чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл аюул заналыг нөлөөлөл болон , хамрах хүрээний хувьд бууруулна.

Ингэснээр хамгаалах биологийн олон янз байдлын экологийн чухал хүчин зүйл үзүүлж буй дарамтыг бууруулж улмаар менежментийн хэтийн зорилго хангагдах ёстой. Аюул заналыг бууруулах зорилт нь тодорхой цаг хугацаатай, хэмжигдэхүйц байх ёстой.

Аюул заналыг бууруулах зорилгын жишээ: 2015 он гэхэд хулгайн анг хувиар бууруулна.

ТХГ-ын амжилтийг дээрх хамгаалах олон янз байдлыг сайжруулаж чадаж буй эсэх, аюул заналыг хэр зэрэг бууруулж байна вэ гэдгээр хэмжих ёстой.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ


3-р хавсралт

Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь:

1. Шалтгаан үр дагаврын шинжилгээ
2. Үр дүнгийн хэлхээс гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэг. Шалтгаан үр дагаврын шинжилгээ

Шалтгаан үр дагаврын шинжилгээг дараах схем дээр харуулав.




Дээрх шалтгаан үр дагаврын шинжилгээг схемээс гадна хүснэгт ашиглан хийж болно. Хүснэгт ашиглаж буй тохиолдолд хоорондын холбоог сумаар зааж харуулах боломжгүй боловч хүснэгт дээр тохируулан харуулах боломжтой.

Тухайн аюул заналыг үүсгэж буй хэд хэдэн шалтгаан байж болох боловч доорх жишээн дээр зөвхөн хоёр шалтгааныг харуулав.

Хүснэгт: Шалтгаан үр дагаврын шинжилгээ (Хүснэгтээр хийх жишээ)


Хамгаалах биологийн олон янз байдал:	Аюул занал:	Шалтгаан:	Шалтгаан:
1. Тарвага	Хулгайн ан	Эргүүл, хяналт шалгалт муу	Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр байхгүй

Хоёр. Үр дүнгийн хэлхээс.



Эдгээр үр дүнгийн хэлхээс нь өмнөх учир шалтгааны дүн шинжилгээнээс урган гарна. Шалтгаан тус бүрийг арилгахад чиглэгдсэн үр дүнг төлөвлөнө. Эхний үр дүн дараагийн үр дүнд шууд хамааралтай байх логик дарааллыг баримтлана.

Үр дүн гарч байвал аюул занал буурч биологийн олон янз байдалд эерэг өөрчлөлт гарна гэсэн дарааллыг баримтлана.





Дээрх жишээн дээр шалтгаанаас хүлээгдэж буй үр дүнг хэрхэн томъёолохыг харуулжээ. Тухайлбал шалтгаан нь “Хуулийн хэрэгжил сул” гэж байвал үр дүнг “Хуулийн хэрэгжилт сайжирсан байна” гэж тодорхойно.

Дээр дурьдсанчлан Үр дүнгийн хэлхээсийг схемээс гадна мөн хүснэгтээр хийж болно.


Хүснэгт: Үр дүнгийн хэлхээс \Хүснэгтээр хийх жишээ\

Хамгаалах биологийн олон янз байдал:	Аюул заналыг бууруулах зорилт:	Үр дүн:	Үр дүн:
1. 20.._ онд тарваганы идэвхитэй нүхний тоо ... болж өссөн байна.	20... онд хулгайн ан ...%-иар буурсан байна.	Эргүүл хяналтын ажил тогтмолжсон байна.	Эргүүл, хяналтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр бүрдсэн байна.
2			
3			

Үр дүнд хүрэх арга замыг тодорхойлох:

Үр дүнд хүрэх арга замыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгоно. Үүнд:

- Аюул заналыг хэр үр дүнтэй бууруулах,
- Богино хугацаанд үр дүнд хүрэх,
- Хэрэгжүүлэхэд хялбар байх,
- Өртөг зардлын хувьд хямд байх,



Хэрэв Мирази программыг ашиглах боломжгүй бол MS word программ дээр эсвэл хүснэгт ашиглан хийж болно.


Хүснэгт: Үр дүнгийн бүрэн хэлхээс \Хүснэгтээр хийх жишээ\

Хамгаалах биологийн олон	Аюул заналыг бууруулах	Үр дүн:	Үр дүн:	Арга зам

янз байдал:	зорилт:			
1.200...онд тарваганы идэвхитэй нүхний тоо ... болж өссөн байна.	20... онд хулгайн ан ...%-иар буурсан байна.	Эргүүл хяналтын ажил тогтмолжсон байна.	Эргүүл, хяналтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр бүрдсэн байна.	Хуулийн хэрэгжилтийг сайжруулах
2				
3				

Арга хэмжээний төлөвлөлтийн схем

4-р хавсралт.



Миради болон CAP программыг ашиглаагүй тохиолдолд төлөвлөлтийг хүснэгтээр хийж болох ба жишээг дор харуулав. Мөн хүснэгт ашиглахгүй текстээр бичиж болно.

Хүснэгт.. Менежментийн хэтийн зорилго, зорилт, арга хэмжээний төлөвлөлт

Хамгаалах биологийн олон янз байдал:	Тарвага
Хэтийн зорилго 1:	20 онд тарваганы идэвхитэй нүхний тоо ... болж өссөн байна.
Шалгуур:	Тарваганы идэвхитэй нүхний тоо
Аюул заналыг бууруулах зорилт 1:	20... онд хулгайн ан ...%-иар буурсан байна.
Шалгуур:	Зөрчлийн тоо
Арга зам :	Хяналт шалгалтыг сайжруулах

Зорилт, арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжих хугацаа	Хариуцах	Төсөв	Биелэлт
Зорилт 1.1 Эргүүл хяналтын 5 баг байгуулах	20.. оны ...-р сар	Мэргэжилтэн₮	
1.1.1. Арга хэмжээ				
1.1.2. Арга хэмжээ				
1.1.3. Арга хэмжээ				

5-р хавсралт

Менежментийн төлөвлөлгөөг хэрэгжүүлэх чадавхийг төлөвлөх зөгварууд

Менежментийн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөсний дараагаар төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, чадавхи, дэд бүтэц, тоног төхөөрөмж, санхүүжилтийг төлөвлөх шаардлагатай.

Хүний нөөцийг төлөвлөх:

Хүснэгт1. Тусгай хамгаалалттай газрын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Хүний нөөц	Одоогийн байдал	Шаардагдах хүний нөөц					
		Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5	Төсөв
Дарга							
Мэргэжилтнүүд							
Байгаль хамгаалагчид							
Туслах ажилчид							

Хүснэгт 2. Боловсон хүчний сургалт, давтан сургалтын төлөвлөгөө

Хүний нөөц	Шаардлагатай сургалтууд
Дарга	Жишээ: <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн менежмент, • Стратеги төлөвлөлт-Бизнесс төлөвлөгөө, • Санхүүгийн менежмент, • Хамгааллын биологи • Компьютер • Зэрлэг амьтан, ургамлын мониторинг

	<ul style="list-style-type: none"> • Зөрчлийн мэдээллийн сан гэх мэт
Мэргэжилтнүүд	<p>Жишээ:</p> <ul style="list-style-type: none"> • Хамгааллын биологи • Компьютер • Зэрлэг амьтан, ургамлын мониторинг • Зөрчлийн мэдээллийн сан • Газар зүйн мэдээллийн систем • Олон нийтийн оролцооны арга гэх мэт
Байгаль хамгаалагчид	<p>Жишээ:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль хамгаалагчийн сургалт, • Байгаль орчны багц хууль, • Зэрлэг амьтан, ургамлын мониторинг, • Зөрчил илрүүлэх, шийдвэрлэх, акт баримт бүрдүүлэх, • Олон нийттэй харьцах арга, • Зөрчлийн мэдээллийн сан гэх мэт

Хүснэгт 3. Дэд бүтэц, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа

Дэд бүтэц, тоног төхөөрөмж	Одоогийн байдал	Шаардагдах дэд бүтэц тоног төхөөрөмж					
		Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5	Төсөв
Дэд бүтэц							
Төв байр							
Байгаль хамгаалагчийн ажлын байр							
Харуулын пост							
Мэдээллийн төв							
Зам тэмдэгжүүлэлт							
Хилийн тэмдэгжүүлэлт							
Бусад							
Оффисийн тоног төхөөрөмж							
Тавилга							
Компьютер							
Принтер							
Бусад							
Тээврийн хэрэгсэл							
Машин							
Мотоцикль							
Морь							
Бусад							
Харилцаа холбооны хэрэгсэл, тоног төхөөрөмж							
Радио холбоо							
Хөдөлгөөнт холбоо							
Аудио-видео							

төхөөрөмж							
Бусад							
Хээрийн аяны хэрэгсэл							
Майхан							
Унтлагын уут							
Гудас							
Бусад							
Байгаль хамгаалагчийн хэрэгсэл							
Дүрэмт хувцас							
Бие хамгаалах хэрэгсэл							
Дуран							
GPS							
Бусад							
Бусад тоног төхөөрөмж, материал							

Хүснэгт 4. Менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв

Хамгаалах биологийн олон янз байдал:					
Хэтийн зорилго 1:					
Шалгуур:					
Аюул заналыг бууруулах зорилго 1:					
Шалгуур:					
Арга зам :					
Зорилт, арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжих хугацаа	Хариуцах	Төсөв	Биелэлт	
Зорилт 1.1.					
1.1.1. Үйл ажиллагаа					
1.1.2. Үйл ажиллагаа					
1.1.3. Үйл ажиллагаа					

Хүснэгт 5. Хамгаалах биологийн олон янз байдлын мониторингийн төлөвлөгөө

Хамгаалах биологийн олон янз байдал	ЭЧХЗ	Шалгуур	Арга зүй	Давтамж	Хэн хариуцах	Төсөв